

БАТЛАВ.  
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА  
Т.НЯМ-ОЧИР

БАТЛАВ.  
МОНГОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГААНЫ  
НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ХИШИГБАЯР



“ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ-СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ  
ХИЧЭЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА” СЭДЭВТ ОНОЛ, ПРАКТИКИЙН IX БАГА  
ХУРЛЫН УДИРДАМЖ

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг (МХСН) нь сургалт арга зүйн байгууллагуудтай хамтран 2013 оноос хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах шинэлэг арга зүй, туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх зорилгоор “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол, практикийн бага хурлыг жил бүр зохион байгуулж ирсэн.

“Хүүхдийн хөгжлийг дэмжих багшлах арга зүй” онол, практикийн VIII бага хурлыг 2023 онд МХСН-ийн 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан билээ. Энэхүү уламжлалт бага хурал нь уралдаан, өрсөлдөөн бус хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн асуудлаар харилцан туршлага солилцох, тулгамдаж байгаа асуудлаа хэлэлцэж, суралцахуйд суурилсан багшийн арга зүйг сайжруулах шийдэл, боломжийг хэлэлцэх талбар болдог.

Энэ удаагийн IX бага хурлыг Боловсролын ерөнхий хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль, Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030), 2024-2025 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилтийг дэмжихэд чиглүүлэн Боловсролын ерөнхий газар, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг хамтран зохион байгуулна.

Энэ удаагийн бага хурлын онцлог нь сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, бууруулахад суралцахуйг дэмжсэн, тэгш хамруулах, идэвхтэй сургалтын аргыг үр дүнтэй ашиглаж хичээлийн судалгаа хэрэгжүүлж буй туршлагыг түгээн дэлгэрүүлэх юм. Аймаг, нийслэлээс шалгарсан илтгэгч оролцох төдийгүй хичээлийн судалгааны эксперт, профессор багш үндсэн илтгэгчээр оролцоно.

## ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**2.1. Зорилго:** Бүх шатны боловсролын байгууллагын багш нар ажлын байрандаа хамтдаа тасралтгүй хөгжих, хүүхдийн хөгжлийг дэмжих, сурлагын хоцрогдлыг бууруулах багшлах арга зүйг боловсронгуй болгон хөгжүүлэх гол арга зам болох **хичээлийн судалгааг** үр дүнтэй зохион байгуулах, бий болсон сайн арга зүй, туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан туршлага солилцох нөхцөлийг бүрдүүлэх.

**2.2. Чиглэл:** “ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖСЭН БАГШЛАХ АРГА ЗҮЙ” онол практикийн IX бага хурал нь 2025 онд “СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ, ИДЭВХТЭЙ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ” (Child centered-Active learning method) дэд сэдвийн дор дараах чиглэлийн хүрээнд зохион байгуулагдана.

- Сургуульд суурилсан хичээлийн судалгаа: Сургуулийн менежментийг сайжруулах, сургуулийн хэмжээнд тулгамдаж буй хүүхдийн хөгжлийн тодорхой асуудлыг шийдэх үүднээс багш, ажилтнууд хамтран хичээлийн судалгааны хүрээнд хийсэн хүүхдийн хөгжил, ахиц өөрчлөлт, үнэлгээний чиглэлийн судалгаа, үр дүн, арга туршлагыг илтгэнэ.
- Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгаа: Тодорхой судлагдахууны арга зүй, технологи, хичээлийн чанарыг сайжруулах зорилгоор хийсэн судалгаа, арга туршлага, технологийн талаар илтгэнэ. Мөн тодорхой судлагдахууны жишээн дээр багшлах болон суралцах шинэ арга зүй, технологи боловсруулан туршсан судалгаа, үр дүнг илтгэнэ.
- Тэгш хамруулах боловсролын судалгаа: Тусгай хэрэгцээт, тэгш хамруулан сургах, хүүхэд нэг бүрийн хэрэгцээнд нийцсэн боловсролын чанарыг сайжруулах чиглэлээр хийж буй судалгаа, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, туршлага, үр дүнг илтгэнэ.

Дээрх чиглэл бүрд сургуулийн өмнөх боловсролоос дээд боловсролын түвшин хүртэлх судалгаа хамрагдана.

**2.3. Илтгэлийн хэлбэр:** Судалгааны цар хүрээ, арга, аргачлал, хүрсэн үр дүн зэргээс хамаарч илтгэлийг үндсэн, салбар хуралдааны, ханын илтгэл гэсэн 3 хэлбэрээр хэлэлцэнэ.

- Үндсэн илтгэл: Багшлах арга зүй, хичээлийн судалгааны чиглэлээр шинэлэг санаа дэвшүүлсэн, тулгамдаж байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, цаашдын хөгжлийн чиг хандлагыг илэрхийлсэн нэгдсэн хуралдаанд танилцуулагдах онол, арга зүйн илтгэл байна.
- Салбар хуралдааны илтгэл: Суралцахуйг дэмжих багшлах арга зүй, хүүхдийн хөгжил, хамгаалал, хичээлийн судалгааны чиглэлээр хийж байгаа судалгааны ажил, практикт туршиж, хэрэгжүүлсэн шинэлэг, бүтээлч арга туршлагыг сургуульд суурилсан, судлагдахуунд суурилсан, тэгш хамруулах боловсрол гэсэн гурван чиглэлээр хэлэлцэнэ.
- Ханын илтгэл: Багшлах арга зүй, хичээлийн судалгааны чиглэлээр сургалт арга зүйн байгууллагын мэргэжилтэн, арга зүйчид, судлаачид, багш бэлтгэх сургуулийн оюутнууд нь хичээлийн судалгааны үр дүнгээ хэвлэмэл (постер) байдлаар танилцуулахаар бэлтгэсэн илтгэл байна.

**2.4. Оролцогчид:**

1. СӨБ, ЕБС-ийн багш, удирдах ажилтан
2. Нийслэлийн Боловсролын газар, аймгийн Боловсролын газрын мэргэжилтнүүд
3. Боловсролын салбарын мэргэжлийн байгууллагын арга зүйч, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан
4. Их, дээд сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын багш, судлаач, багш мэргэжлээр суралцаж буй оюутан суралцагчид багаар болон ганцаарчлан оролцож болно.

**2.5. Хугацаа:** 2025 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулна. (Жич: Хурал зохион байгуулах өдрийг 2025 оны 3 дугаар сард албан ёсоор мэдэгдэнэ.)

**2.6. Илтгэл хүлээж авах:** Илтгэлийн хураангуй болон дэлгэрэнгүйг 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны өдрийн 18 цаг хүртэл цахимаар хүлээн авна. Цахим бүртгэлийн холбоосыг 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс Боловсролын ерөнхий газрын <https://edu.gov.mn/>, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн <https://mals.mn/> вэб хуудаст байршуулна.

Хуралд ирүүлсэн илтгэлтэй экспертийн баг танилцаж, шалгаруулалт хийх, зөвлөмж өгч, сайжруулах, хурлын зохион байгуулалтын зардалтай холбоотойгоор илтгэлийн тоогоор хураамж төлөх бөгөөд Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн Голомт банкны 1410013273 тоот дансанд хураамжийг шилжүүлж, баримтыг зураг хэлбэрээр илтгэлийн хамт илгээнэ. (Үндсэн болон салбар хуралдааны илтгэл 40,000 төгрөг, ханын илтгэл 30,000 төгрөг). Илтгэлийн хураамж нь илтгэл уншиж шалгаруулах экспертийн ажлын хөлс, хурлын илтгэлийн хэвлэлийн эх бэлтгэлийн зардалд зарцуулагдана.

**2.7. Илтгэлийг хэлэлцэх:** Илтгэлийг хоёр үе шаттай хэлэлцэнэ.

- 1-р үе шат: Мэргэжлийн комисс (экспертийн баг) тодорхой шалгуурын дагуу ирүүлсэн илтгэлүүдийг уншиж, онол практикийн бага хуралд хэлэлцэх илтгэлийг сонгоно.
- 2-р үе шат: Онол практикийн бага хуралд сонгогдсон илтгэлийг хэлэлцүүлнэ.

**2.8. Шалгаруулалт, урамшуулал, зардал:**

Онол, практикийн бага хуралд нэгдүгээр шатанд илтгэл нь шалгаран хэлэлцэгдсэн бүх илтгэгчид батламж олгох бөгөөд илтгэлийн хураангуйд оруулан хэвлүүлнэ. Илтгэлийн дэлгэрэнгүйг цахим хэлбэрээр Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг болон Боловсролын ерөнхий газрын веб сайтаар түгээнэ.

Хичээлийн судалгаагаар дамжуулан хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн шинэлэг туршлага бий болгосон, багшийн арга зүй, суралцагчийн хөгжлийг дэмжихэд үр нөлөө бүхий **гурван илтгэлийг** шалгаруулан илтгэгчийг “Гадаад, дотоодын сургалт, туршлага судлах үйл ажиллагаа”-нд хамруулахад дэмжлэг үзүүлнэ. Илтгэлийг багаар боловсруулсан бол багийн ахлагчид урамшууллын эрхийг олгоно.

Онол, практикийн хурлын нэгдүгээр шатнаас шалгарч, хэлэлцэгдэх илтгэл тавих илтгэгч нь замын зардлаа өөрөө хариуцана. Аймаг, нийслэлийн Боловсролын газар нь хуралд оролцох багийг зохион байгуулж оролцоно. Өмнөх жилүүдэд зохион байгуулагдсан “Хүүхдийн хөгжил-Хичээлийн судалгаа” сэдэвт бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэлийг, хичээлийн судалгааны илтгэл бичих зөвлөмж, илтгэлийн бүтэц, жишээг [www.edu.gov.mn](http://www.edu.gov.mn), [www.mals.mn](http://www.mals.mn) сайтаас харна уу.

## ГУРАВ. ИЛТГЭЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, АГУУЛГАД ТАВИХ ШААРДЛАГА

### 3.1 Сургуульд суурилсан хичээлийн судалгааны илтгэлийн бүтэц:

ИЛТГЭЛИЙН

НЭР:

Илтгэгч: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, имэйл хаяг

Илтгэлийг хамтран боловсруулсан багийн гишүүд: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, e-майл хаяг  
ХУРААНГУЙ

- Зорилго
- Судалгааны загвар (арга зүй) хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг
- Товч агуулга: 200-250 үг

ИЛТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Удиртгал

Онол, арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл (Тулгамдсан асуудал, сургуулийн зорилго, тэргүүлэх зорилт, гол үйл ажиллагаа, сэдэв, ...)
- Хамрах хүрээ: Хэддүгээр ангийн хэдэн сурагчид хамрагдсан болох, хэдэн багш, ажилтан хамрагдсан болох
- Үр дүн гарахад зарцуулсан хугацаа

Хугацаа:

- Энэхүү судалгааг ямар хугацаанд хийсэн болох

Хэрэгжүүлсэн байдал

- Гол үйл ажиллагаа (Товч: Суралцагчдын төлөвшил, хандлага, хөгжил, суралцахуйн ямар асуудлыг шийдэх чиглэлээр сургуулийн хэмжээнд хичээлийн судалгаа зохион байгуулсан .....)

Судалгааны үр дүн

- Зорилгодоо хүрсэн байдал: Дээрх үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж чадсан эсэхийг нэгтгэн дүгнэх, үр дүнтэй болсон эсэхийг шинжлэх
- Яагаад сайн болсон бэ?
- Бусдад хүргэх туршлага
- Цаашид хөгжүүлэх санал

Ном зүй

**3.2. Судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааны илтгэлийн бүтэц**  
(тодорхой хичээлээр болон интеграц агуулгаар хийсэн хичээлийн судалгааны үр дүн, арга зүй, туршлага):

СУДЛАГДАХУУН:

ИЛТГЭЛИЙН НЭР:

Илтгэгч: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, имэйл хаяг

Илтгэлийг хамтран боловсруулсан багийн гишүүд: Овог, нэр, аймаг (нийслэл), сум (дүүрэг), сургууль, утасны дугаар, имэйл хаяг

ХУРААНГУЙ

- Зорилго
- Судалгааны загвар (арга зүй) хандлага
- Судалгааны үр дүн
- Практик ач холбогдол
- Шинэлэг тал/санаа
- Түлхүүр үг
- Товч агуулга: 200-250 үг

ИЛТГЭЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Удиртгал

Онол арга зүйн үндэс, судалгааны загвар:

- Сэдвийг сонгосон үндэслэл (Асуудал)
- Хичээлийн санаа
- Хичээлийн бэлтгэл судалгаа
- Судалгаат хичээл

Хичээлийн өрнөл хэсгийн шийдэл (мэдлэг бүтээлгэх)

- Хүүхдээр юуг, яаж нээлгэсэн тухай алхмууд (Таамаглал/Асуудал дэвшүүлэх, таамаглалаа шалгах, асуудал шийдэх, турших, хэлэлцэх гэх мэт)
- Чухал шинэлэг санаа, арга зүйн туршлага

Судалгааны үр дүн

- Судалгаат хичээлээр хичээлийн төлөвлөлтөд хийсэн зарим сайжруулалт
- Судалгаат хичээлийн төлөвлөлтийн ерөнхий санаа: Багшийн асуулт-үндсэн үйл ажиллагаа, тухайн хэсгийн шийдэл-гол санаа
- Хичээлийн хэсэг тус бүрийн шийдлийг хэрэгжүүлсэн байдал: Хичээлийн үеийн протоколын хэсгээс ишлэл хийж, тайлбарлах байдлаар хичээлийн төлөвлөлтийг (хичээлийн эхлэл, өрнөл, төгсгөл) хэрэгжүүлсэн байдлыг танилцуулна.

Дүгнэлт:

- Яагаад сайн хичээл, үйл ажиллагаа болсон, сайжруулалтыг хэрхэн хийсэн?
- Бусдад хүргэх туршлага
- Бусад

Ном зүй

### **3.3. Мэргэжлийн багийн гишүүд, судлаачдын үндсэн болон хэлэлцүүлэгт илтгэлийн бүтэц**

- Гарчиг 12pt том үсгээр эхэлж жижиг үсгээр бичнэ.
  - Зохиогчдын нэр, байгууллага, хаяг, 9pt, налуу, том үсгээр эхэлнэ.
- Товч утга (монгол хэл дээр бичих)
- Түлхүүр үг (заавал биш)
- Удиртгал
- Үндсэн хэсэг
  - Онол, арга зүй
  - Туршилт судалгааны хэсэг
- Үр дүн, дүгнэлт
  - Талархал
  - Ишлэл буюу ном зүй

### **3.4. Илтгэлийн бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлага**

#### **1. Цаасны хэмжээ ба зай авах:**

- Цаасны хэмжээ А4 байх.
- Бичиглэл дээд талаасаа 2.5 см, доод талаасаа 2.5 см, зүүн талаасаа 3 см, баруун талаасаа 1.5 см, мөр хоорондын зай 1.15 см байх.

#### **2. Хэл:**

Өгүүллийг MS word программ дээр “Times new roman” фонт ашиглан үсгийн өндөр 11pt-ээр монгол хэл дээр бичнэ. Илтгэлийн хураангуйг монгол хэл дээр “Times new roman” фонт ашиглан бичнэ.

#### **3. Илтгэлийн бичиглэлд тавигдах шаардлага:**

- Ишлэлийг дөрвөлжин хаалтанд [зохиогчийн нэр, он] загвараар хийнэ.
- Тооны аравт, зуутын орны таслалыг цэгээр тэмдэглэнэ.
- Томьёог налуугаар бичнэ.
- Зохиогчдын нэр, байгууллага, хаяг нь том үсгээр эхэлж, үсэг нь 9pt-ийн өндөртэй, налуугаар бичнэ. Мөн илтгэлийн хураангуйг 9pt-ийн өндөртэй бичнэ.
- Товч утга нь 200-250 үгтэй байна.
- Илтгэлийн дэлгэрэнгүйн үсэг нь 11pt-ийн өндөртэй, мөр хоорондын зай 1.15 см байна.
- Эшлэлийн үсгийн өндөр нь 10pt байна. Ишлэлийг Microsoft Word программын reference цэсний insert footnote ашиглан хийнэ.
- Ном зүйг Microsoft Word программын reference цэсний Citation&Bibliography-г ашиглан APA style – аар хийнэ.

### 3.5. Анхаарах зүйл:

- Илтгэлийн хураангуйг MS Word программ ашиглан бичвэр, хэлбэржүүлэлтэд тавих шаардлагын дагуу А5-ын 2 нүүрээс илүүгүй бэлтгэх.
- Аман илтгэлийн хугацаа 15 минут байхаар тооцох. Үзүүлэх материалыг MS Power Point, Prezi программын ашиглан бэлтгэх. Сайжруулсан хичээлийн хөтөлбөр, хичээл ажиглалтын хуудас, хэлэлцүүлгийн протокол, фото зураг, видео бичлэг зэрэг баримтуудыг хавсаргаж болно.
- Ханын илтгэлийг 120:80 см хэмжээтэй фото цаасан дээр хэвлүүлнэ.

### **ДӨРӨВ. БАГШЛАХУЙН АРГА ЗҮЙН САЙН ТУРШЛАГЫГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ**

- 4.1. Онол, практикийн бага хурлын өмнө илтгэлийн хураангуйг бэлтгэнэ.
- 4.2. Онол, практикийн хурлын дараа бичвэр ба илтгэл тавигдах шаардлага хангасан илтгэлүүдээр хурлын илтгэлийн эмхэтгэл гаргана.
- 4.3. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүйн сайн туршлага бүхий үр нөлөөтэй илтгэлийг Боловсролын ерөнхий газрын [www.edu.gov.mn](http://www.edu.gov.mn) веб сайт, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгийн [www.mals.mn](http://www.mals.mn) веб сайтад байршуулна.

Холбоо барих:

Утас: 99775896 (Ц.Лхамсүрэн, БЕГ), 94490108 (Б.Хишигбаяр, МХСН)

Имэйл хаяг: [lkhamsuren@agency.edu.mn](mailto:lkhamsuren@agency.edu.mn), [mals.mongolia@gmail.com](mailto:mals.mongolia@gmail.com)